



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/572

Номгон


Малын гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх,  
урьдчилан сэргийлэх шуурхай штаб, ажлын  
хэсэг байгуулах тухай

Олон улсын хорио цээрт малын гоц халдварт шүлхий өвчин манай аймагт зөөвөрлөгдөн оношлогдсонтой холбоотойгоор Шүлхий өвчний гаралт, тархалтыг зогсоох, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг яаралтай зохион байгуулах зорилгоор Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3. "а" дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 62 дугаар хуралдааны шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Малын гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах "Шуурхай штаб"-ыг нэгдүгээр, Шүлхий өвчний тандалт судалгааны багийг хоёрдугаар, Вакцинжуулалтын ажлын хэсгийг гуравдугаар хавсралтаар тус тус байгуулсугай.

2.Дээрх ажлыг чанартай, үр дүнтэй зохион байгуулж аймгийн Онцгой комиссын хуралд тайлагнан, мэдээллээр хангаж ажиллахыг Ажлын хэсгүүдэд даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын газрын дарга, хурандаа (Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

601\*10329

Аймгийн Засаг даргын ..... оны ..... сарын .....  
өдрийн 1/572 дугаар захирамжийн нэгдүгээр

хавсралт

МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ,  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ,  
МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙГЭЭР ХАНГАХ "ШУУРХАЙ ШТАБ"-ЫН  
БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч  
Гишүүд:

Б.Батсуурь – Аймгийн Засаг даргын орлогч  
Ж.Баттөр – Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга  
Б.Оюутболд – Цагдаагийн газрын дарга  
Р.Мэндбаяр – Тагнуулын хэлтсийн дарга  
Ж.Алтангэрэл – Онцгой байдлын газрын дарга  
Н.Бямбадорж – Мэргэжлийн хяналтын газрын  
дарга

Б.Ганзориг – Байгаль орчин, аялал жуулчлалын  
газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч  
Д.Алтангэрэл – Газрын харилцаа, барилга хот  
байгуулалтын газрын дарга

Нарийн бичгийн дарга

Сумдын Засаг дарга нар  
Л.Оюун-Эрдэнэ – Мал эмнэлгийн газрын дарга

оОо

Аймгийн Засаг даргын \_\_\_\_\_ онд \_\_\_\_\_ сарын 14  
өдрийн 157 дугаар захирамжийн хоёрдугаар




МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧНИЙ ТАНДАЛТ  
СУДАЛГААНЫ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч Д.Мөнгөнтулга – Цагдаагийн газрын Нийтийн хэв журмыг  
хамгаалах тасгийн дарга  
Б.Золжаргал – Тагнуулын хэлтсийн ахлах ажилтан  
Г.Баярсайхан – Онцгой байдлын газрын Гамшгаас  
хамгаалах улсын хяналтын байцаагч  
Э.Адъяасүрэн – Мал эмнэлгийн газрын Мал, амьтны  
эрүүл мэндийн албаны дарга  
Ж.Өлзийжаргал- Мал эмнэлгийн газрын Зооноз,  
халдварт өвчин, тандалт хариуцсан мэргэжилтэн  
Т.Ууганцэцэг – Зооноз өвчин судлалын төвийн амьтан  
судлаач  
Сумдын Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч,  
Тархвар зүйч  
Сумдын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүд  
Багийн Засаг дарга нар  
Нарийн бичгийн дарга Л.Оюун-Эрдэнэ – Мал эмнэлгийн газрын дарга

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_

Аймгийн Засаг даргын 2024 оны 09 сарын 14  
өдрийн 1572 дугаар захирамжийн гуравдугаар



**МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧНИЙ  
ВАКЦИНЖУУЛАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн ахлагч: Л.Оюун-Эрдэнэ – Мал эмнэлгийн газрын дарга  
Гишүүд: Г.Өлзийнаран- Мал эмнэлгийн газрын Улсын  
ахлах байцаагч  
Сумдын Мал эмнэлгийн тасаг  
Сумдын Мал эмнэлгийн аж ахуй нэгжүүд  
Нарийн бичгийн дарга: Э.Адъяасүрэн – Мал эмнэлгийн газрын Мал,  
амьтны эрүүл мэндийн албаны дарга

оОо